

НОМ ЗҮЙ, ЛАВЛАХ

**ПОЛЬШИЙН СУДЛААЧ  
ХЯТАДЫН ТУХАЙ**

В. Роджиньски. «Хятадын түүх» Вроцлав,  
Варшав, Краков, Гданьск, Оссолинэум,  
1974. 731 х\*

Польшийн эрдэмтэн Витольд Роджиньскийн бичсэн «Хятадын түүх» ном 1974 онд Оссолинэум хэвлэлийн газарт хэвлэгдэн гарчээ. Гадаад орнуудад гарч буй Хятадын судлалын ном зохиол бидний анхаарлыг ихэд татдаг. Эрдэмтэн В. Роджиньскийн бичсэн «Хятадын түүх» хэмээх зохиол нь сүүлийн үед Польшийн хятад судлалд гарсан томоохон бүтээлийн нэг гэж үзэж болох юм. Польшид хятадын түүх судлалаар нэрд гарсан И. Хмелевский, В. Яблоньски, О. Войтасхевич, И. Лобман зэрэг эрдэмтдийн бичсэн цөөн бүтээлийг бид мэдэх билээ.

Витольд Роджиньски хятадын түүхийг 35 жил хичээнгүйлэн судалж, 1953—1967 онуудад БНХАУ-д олон удаа очин өөрийнхөө судалгааны ажлаа Хятад талын ховор сурвалж баримтаар улам баяжуулсан нь түүний эрдэм шинжилгээний зохиол бичихэд нь үнэнхүү чухал ач холбогдолтой болжээ.

«Хятадын түүх» хэмээх эл зохиолд юуны өмнө хан (хятад) үндэстний түүхийг голчлон авч бичжээ. Гэхдээ одоогийн БНХАУ-ын доторхи бусад ястан угсаатны түүхийг орхигдуулсангүй.

Хятадын түүхийг бичихдээ зөвхөн ханчуудын түүхийг бичээд зогсохгүй хөрш зэргэлдээ оршиж байсан олон аймаг угсаатны түүхийг нэгэн зэрэг бичиж тэдний өөр хоорондын бүх талын шүтэлцээ холбоо, соёл иргэншлээр харилцан нөлөөлж байсан нөлөөллийг тодорхой бичих нь зүйтэй гэж зохиогч үзжээ.

Зохиолын эхний бүлгүүдэд зэргэлдээ улс орнуудын талаар Хятадын хаад, ноёдын явуулж ирсэн эзэрхэг түрэмгий бодлогыг дэлгэрэнгүй өгүүлснээс гадна Хятадын нутаг дэвсгэрийн хэсгийг эсвэл бүхийлд нь байлдан дагуулж байсан бусад үндэстэн угсаатны түүхийг нэгэн зэрэг нилээд тод томруун өгүүлж бичжээ. Зохиолын давуутай тал гэвэл хятадын эх сурвалж материалыг нэн эрт үеэс эх хэлээр нь авч ашигласанд оршино. Гэхдээ хятад сурвалжид бас байнга шүүмжилтэй хандсан нь үзэгдэнэ.

Хятадын, түүхийг балар эрт үеэс нь аваад 1919 оны 5-р сарын 4-ний хөдөлгөөн хүртэл бичсэн энэхүү дорвилог бүтээл нийт 731 тал хуудастай бөгөөд Хятадын түүхийн бүхий л үеийг хураангуйлан бичихдээ Хятадын шинэ үеийн түүхийн асуудалд номын нилээд хуудсыг зориулжээ. Номонд Хятадын түүхийн үечлэлийн асуудал одоо хирнээ санал зөрөөтэй хэвээр байна. Ялангуяа Хятадын шинэ түүх, нэн шинэ түүхийн аль ч үеийг судлахад түүнд хятад, эртний түүхийн хэвшсэн уламжлалт ёсны нөлөө үлэмж их тусгал олж байдаг юм. Энэ талаар Хятад шиг тийм улс дэлхийд бараг байхгүй бизээ. Чухам энэ утгаар аваад үзсэн ч Хятадын түүх үнэхээрийн онцлогтой юм гэж тэрээр бичсэн нь сонин дүгнэлт юм.

В. Роджиньски өөрийнхөө зохиолд Хятадын түүхийг үечлэхдээ «Дундад зууны үе» гэдэг томъёоллыг хэрэглээгүй байна. Учир нь хэрвээ Хятадын түүхийг дундад зууны үеэр үзвэл тэр нь «евроцентризм» болно.

\* Witold Rodzinski "HISTORIA CHIN", Ossolineum, 1974

Яагаад гэвэл Хятад оронд феодалын нийгэм хамгийн олон жил маш удаан хугацаатай тогтож байсан болохоор дундад зууны үе гэж дэлхийн түүх бичлэгийн хэмжээнд оруулж хуваахад бэрх юм гэж бичжээ.

Зохиогч Хятадын эртний түүхийг славян аймгуудын түүхийн хөгжилтэй нэлээд төстэй байж болох юм гэж үзжээ.

Өөрөөр хэлбэл Шан, Ингийн (МЭӨ XXI—XVIII) үеийн өмнөх Хятадын нийгэм овгийн хэлбэрээс боолын нийгмийг алгасан феодализмд шилжин орох хамгийн эхний үе байсан. Харин Чжоу улсын үед Хятадад феодализм үзэгдэхүйц хөгжсөн гэжээ.

Хятад нь Зүүн-Өмнөд Азид хамгийн түрүүнд феодализмд шилжин орсон улс мөн болох нь хэдийгээр магадтай мэт боловч Монгол, Зөвлөлт болон бусад орны эрдэмтдийн үзэж байгаагаар Чжоугийн үед Хятадад боол эзэмших нийгэм үүсч байсан бөгөөд харин Хятадад феодалын нийгэм үүсч хөгжсөн нь Хан улс мөхсний дараа буюу МЭ III—IV зуунд хамаарагдах зүйл гэж үздэг. Зохиогч номондоо МЭӨ 221—207 онд оршин тогтнож байсан Цин улсын Шихуан хааны үйл ажиллагааг өгүүлэхдээ хэдийгээр Хятадыг нэгтгэхэд тодорхой үүрэг гүйцэтгэсэн боловч тухайн үед түүний явуулж байсан харгис хэрцгий бодлого нь улс төрийн аль ч утгаар авч үзсэн тэр дэлхий ертөнцөд хэзээ ч үзэгдээгүй тийм зүйл байсан юм. Үүнээс үзэхэд Хятадын эзэн хаадын харгис хэрцгий дээрэнгүй бодлого нь нэн эртнээс үүсч хөгжиж улмаар уламжлал болж хэвшсэн нь тодорхой гэжээ.

Тэрээр МЭӨ 202—МЭ 8 онд Хятадын баруун Хан улсын оршин тогтнож байсан үеийг бичихдээ хөрш зэргэлдээ байсан Хүннү улсын Модун хааны үйл ажиллагааг сонирхон бичээд тэр үед Хятадын Хан улс нь хөрш нүүдэлчин улс Хүннүгийн хүчинд үнэхээр дийлдэн автагдаж арга буюу их хэмжээний өргөл барьц барьж, төлбөр төлж, бас гүнж өгч байсан байна.

Гэвч Хятадын зарим түүхчид үүнийг одоо үед өөр утгын дор өөрчилсөн билээ. Мөн МЭӨ 129—119 онд Хан улсын Уди хаан Хүннү улсын (Монгол улс Н. Б.) эсрэг хэд хэдэн удаа аян дайн хийж гүйцэд ялан дийлээгүй боловч түүний хүчийг зохих хэмжээгээр сулруулсан байна. Хан улсын Уди хааны дэгдээсэн тэр удаан хугацаагаар үргэлжилсэн дайнд Хүннүгийн нүүдэлчин ард түмний аж ахуй хүнд байдалд ороод зогсоогүй дотоодын хөгжилд асар их хохирол учруулсан байна. Хятадтай хөрш орших нүүдэлчин улс орон, аймаг угсаатны язгууртан зонхилгч нарын хооронд үүссэн аливаа зөрчил тэмцлийг хятадын хаант төрийн зүгээс цаг ямагт овжин ашиглаж өөр хооронд нь мөргөлдүүлэн тэмцэлдүүлж хүчийг нь сулруулах арга тактикийг байнга баримталж ирсэн тухай тодорхой өгүүлжээ.

XIII—XIV зууны Юань гүрний үеийн түүхийг өгүүлэхдээ монголчууд бол Манж нарыг бодвол Хятадыг байлдан дагуулсныхаа дараа хятадчилах процессод автаагүйгээрээ онцлог юм. Үүний гол шалтгаан бол монголчууд нь зан заншил, соёл иргэншил зэрэг бүх талаараа хятадуудаас нэн их өвөрмөц ялгаатай бөгөөд тухай үед Хятад нь Монголын эзэнт Юань гүрэн дотор багтаж байсан туурга тусхай улс байсанд оршино гэжээ.

Юань гүрний үед Хятадад христосын шашин дэлгэрч, Монголын феодал ноёдын дотор нестроанизмыг шүтдэг хүмүүс ч цөөнгүй байжээ. Тухайн үед Монгол, Хятад, Европын орнуудын хоорондын харилцаа ихэд хөгжин өргөн цар хүрээтэй болжээ.

Юань гүрний үед бий болсон тийм өргөн харьцаа лав л XIX зуун хүртэлх Хятадын түүхэнд байсангүй. «Өрнөтийн улсуудын ихэнх худал-

даачид, лам нар Монголын их хааны газар нутагт очиж үзэхийг хүсч байв». Венецийн худалдаачин Марко Поло Монгол гүрэнд очиж дорно зүгийн улс орны талаар тухайлбал Монгол, Хятадын талаар их зүйлийг танин мэдэж Хубилай хааны улсын газар нутгаар чөлөөтэй аялан алба хааж байгаад нутагтаа буцаж ирээд «Марко Пологийн аяны тэмдэглэл» гэдэг номоо хэлж бичүүлсэн нь түүх судлалд үнэхээрийн үнэ цэнэтэй ховор нандин материал болон үлджээ. Энэ номыг Марко Поло олзлогдоод Генуеийн шоронд сууж байхдаа үзсэн харсан шинэ соргог бодит баримтад тулгуурлан бичсэн ажээ. Иймээс түүний бичсэн энэхүү зохиол нь яг л үнэн бодитой зүйлийг онож бичсэн байх учиртай билээ. Өөрөөр хэлбэл, миний бодоход Марко Пологийн аяны тэмдэглэл нь тухайн үеийг хамгийн бодитоор өгүүлсэн цорын ганц зохиол хэмээн үзэхэд даан ч дэгэсдүүлэхгүй байх гэж бодно гэжээ.

Зохиогч номондоо Польшийн түүхтэй холбогдуулан зарим сонирхолтой баримтыг бас дурджээ. Ромын папын элчээр Plano Карпини Монголд зарагдан явахдаа Вроцлав хотын лам Бэнэдикт гэгч польш хүнийг орчуулагчаар авч яваад 1246 онд Монголын хаан Гүегтэй уулзсан байдаг гэж өгүүлжээ.

Зохиогч номондоо Хятадыг эзэлж байсан харийн түрэмгийлэгчдийн дарлал мөн дотоодын феодал, газрын эздийн давхар дарлалд нэрвэгдэж ирсэн Хятадын ард түмний тэмцэл хөдөлгөөний нарийн учир шалтгаан, гүйцэтгэсэн гол үүргийг тодорхой дүгнэн бичжээ.

Мөн түүнчлэн Хятадын зарим түүхчдийн зуршил болсон дутагдал болох аливаа нэгэн дэвшилт зүйл бүхнийг зөвхөн «манайх», «Хятадынх» гэж үзээд өөрсдийгөө хэт дэвэргэн магтдаг үзэл оролдлогыг шүүмжилсэн байна.

Хятадын ард түмний цуцалтгүй хөдөлмөрөөр буй болсон соёл, урлаг, шинжлэх ухаан-техник, үйлдвэрлэлийн арга барилын хөгжилтийг түүхэн үеийн дагуу баялаг материал дээр үндэслэн тод томруун харуулж нийт 106 гэрэл зургийг номондоо багтаасан нь онц сонирхолтой болгожээ. Тэдгээр зургийн ихэнхийг зохиогч өөрөө авсан байна. Мөн хятадын түүхтэй холбогдох 19 тооны газрын зураг хавсаргажээ.

1919— 1949 он хүртэлх Хятадын түүхэнд гарсан гол гол чухал үйл явдлын он дарааллын хэлхээс хийжээ.

Зохиолч ном зүй хийхдээ хятадын түүх, соёлын тухай ном зохиолыг үндсэнд нь хоёр хувааж, эцэст нь Хятадын тухай ерөнхийд нь өгүүлсэн зохиолуудын нэрийг нямбай жагсааж тэдгээрт товч тайлбар хийжээ. Хятадын түүхийн тухай энэхүү номонд Ван Вэньлан, Жун Чимин, Линь И, Ху Шэн, Шан Юэ, Ли Чэннун, Ли Унбин зэрэг хятадын түүхчдийн ном европ, америкийн түүхчид О. Франк, М. Гранст, Р. Гроусет, П. Вегер, Х. Кордиер, Х. Масперо, Е. Балас, Е. О. Райжауэр, И. К. Фэйрбанк, А. Крэйг Л. К. Гудрих, В. Эбэрхард, С. В. Уильямс, К. Р. Фитсжеральд, Зөвлөлтийн Г. Б. Эринбург, М. Ф. Юрьев, Л. В. Симоновская болон бусад түүхчдийн 63 ном, соёлын тухай өгүүлсэн нийт 220 гаруй ном, зохиолыг жагсааж тэдгээрийг археологи, гүн ухаан, шашин, түүх бичлэг, уран зохиол, хэл шинжлэл, урлаг хэмээн ангилж мөн тус бүрт нь товч тайлбар хийжээ.

В. Ролжиньский бичсэн энэ зохиол хятадын түүх судлалд зохих хувь нэмэр оруулсан бүтээл болсноос гадна Монголын түүхийн судлалд ч хэрэгтэй сонин мэдээ бас байна.

Н. Баярбаатар